

## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

### Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

### Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: Жагсаалтад бүртгэлтэй тухайн байгууллагын цахим шуудангаар бичиг баримтаа бүрэн бүрдүүлэн илгээнэ.

### Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага				Утас	Цахим хаяг
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага		
<b>ЭРХЭЛСЭН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛ</b>												
1	Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Ажлын алба	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга	1	Удирдах	ТЗ-2	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Эрх зүй/042/ -боловсрол/01/ -эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /09/ -хүмүүнлэг /022/ -бизнес ба удирдахуй /041/ -хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэл зүй /08/ -нийгмийн шинжлэх ухаан /03/ -мэдээлэл, харилцаа холбооны технологи /06/ -инженерчлэл, үйлдвэрлэл, зохилн бүтээлт /07/	-Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх -Төрийн удирдлагаар эсвэл нийгмийн удирдлагаар мэргэшсэн байх. -Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх ./Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 90 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4 - өөс доошгүй жил ажилласан байх. /Төрийн албан тухай хуулинд энэ заалтад 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 90 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./	70350495	Orkhonith33@gmail.com

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ